



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2025 он	Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: Oyun-Erdenet@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn Аудитор: Б.Мягмарсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Myagmarsurenby@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 8

 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 8

 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 8

 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд 8

4. АУДИТЫН ТАЙЛАН 8

 4.1 Ерөнхий зүйл 8

 4.2 Материаллаг байдал..... 8

 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 8

 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 8

 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 8

 4.5.1 Завсрын аудитын талаар 8

 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 8

5. Аудитын илрүүлэлт 8

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн удирдлагын орлон, 7-р байр, Сайншалан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208. Цахим хаяг: dundgoviaudit.gov.mn	ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА А.ЖАВХЛАН ТАНАА
482503.15 № 93	
таныг -ны № -т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Асуудлыг онцолсон хэсэг Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, сумын бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.6 дахин өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2 албан хаагч 16.5 сая төгрөгийн дэмжлэг авсан байна. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 42.3 сая төгрөгийн хөрөнгийг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна. Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдэл 2023 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс зөрүүтэй байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл, улсын төсвийн байгууллагын төвлөрүүлсэн дүнг устгал хийсэнтэй холбоотой байна. Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Аудитын гол асуудал Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд	

4825020315

нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь шатахууны тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооллогыг чанаргүй хийж тооцоо бодсон акт зөрүүтэй үйлдсэн, Орон нутгийн хөгжлийн сан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зураг төсөвгүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн асуудал байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 16 арга хэмжээ, 144 заалтыг тусган хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үнэлгээгээр 49.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроон 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,333,743.3	1,842,194.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	916,866.2	918,043.7
33	АВЛАГА	205,933.3	700,750.4
35	БАРАА МАТЕРИАЛ	210,943.8	211,024.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	12,376.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,365,661.3	4,881,907.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,365,661.3	4,881,907.8
39200	Биет хөрөнгө	4,191,445.6	4,708,020.3
39300	Биет бус хөрөнгө	174,215.6	173,887.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,699,404.6	6,724,101.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,307.4	44,619.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,307.4	44,619.4
41300	Өглөг	42,307.4	44,619.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,657,097.2	6,679,482.5
51	Засгийн газрын хувь оролцоо	5,657,097.2	6,679,482.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	895,186.8	895,186.8
51200	Хуримтлагдсан үр дүн	4,761,862.0	5,784,247.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	48.4	48.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,699,404.6	6,724,101.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,781,021.2	3,670,564.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	450,405.7	652,621.1
110	Орлогын албан татвар	156,992.8	386,867.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	156,992.8	386,867.4
113	Хөрөнгийн албан татвар	123,134.1	65,404.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	170,278.7	200,349.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	995,873.0	935,739.1
120	Нийтлэг татварын бус орлого	995,873.0	935,739.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,334,742.5	2,082,204.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,327,287.5	1,670,993.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,327,287.5	1,670,993.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,871.7	1,629,118.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,317.5	542,342.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,533.1	61,019.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,801.0	366,717.8
2104	Хангамж, бараа материалын зардал	63,429.0	72,668.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,151.3	40,701.3
2107	Томилолт, зочны зардал	13,644.0	16,686.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,192.4	29,539.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	519,803.5	499,443.4

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,415.8	41,874.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,453,733.6	1,999,571.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	780,119.1	1,067,747.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	673,614.5	931,824.0

12,866.4 мг 8,623.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,983,858.2	4,983,858.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-375.5	-375.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,983,482.7	4,983,482.7
9	Тайлант үеийн үр дүн	673,614.5	673,614.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,657,097.2	5,657,097.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,657,097.2	5,657,097.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	90,561.4	90,561.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,747,658.6	5,747,658.6
19	Тайлант үеийн үр дүн	931,824.0	931,824.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,679,482.5	6,679,482.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,976,701.0	2,859,034.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	450,405.7	652,621.1
110	Орлогын албан татвар	156,992.8	386,867.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	156,992.8	386,867.4
113	Хөрөнгийн албан татвар	123,134.1	65,404.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	170,278.7	200,349.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,277.3	2,798.3
1181	Газрын төлбөр	167,001.4	197,551.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,552.8	124,209.0
120	Нийтлэг татварын бус орлого	191,552.8	124,209.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,334,742.5	2,082,204.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,176,208.8	1,333,992.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,176,208.8	1,333,992.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,143,679.1	1,292,118.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,966.6	540,713.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,783.7	62,898.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,625.9	369,892.9
2104	Хангамж, бараа материалын зардал	40,660.5	48,501.4
2105	Норматив зардал	2,579.0	1,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,032.5	43,372.0
2107	Томилолт, зочны зардал	13,644.0	16,686.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,492.4	32,923.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	381,894.6	176,030.3

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,529.8	41,874.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	800,492.2	1,525,041.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	802,274.3	1,523,863.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	802,274.3	1,523,863.9
2200	Дотоод эх үүсвэрээр	802,274.3	1,523,863.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-802,274.3	-1,523,863.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-81,500.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	81,500.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-83,282.2	1,177.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000,148.4	916,866.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	916,866.2	918,043.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,732,016.0	2,772,154.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,503,774.4	1,253,090.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,471,860.6	1,223,564.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,520.9	540,713.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,126.2	62,898.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,970.0	357,107.7
2104	Хангамж, бараа материалын зардал	54,704.0	48,501.4
2105	Норматив зардал	1,100.0	1,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,463.3	48,172.0
2107	Томилолт, зочны зардал	17,840.0	16,686.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,663.3	12,862.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,472.9	135,523.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,913.8	29,525.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,913.8	29,525.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,111,910.9	1,519,063.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	116,330.7	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,732,016.0	2,827,079.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,405,107.9	1,348,904.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,505,736.4	1,364,562.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	821,171.7	113,612.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	677,836.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	732,761.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,761.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,761.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,412.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,785.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,060.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,566.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,349.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,349.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,761.5

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,761.5
------	-----------------------------	----------

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

3.1. Албан шаардлага

3.1.1 Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 28,800,000.0 /хорин найман сая найман зуу/ төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ /заасныг;

3.1.2 Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 2 захирамж, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий 26 зарлагын мөнгөн гүйлгээ нийт 28 мэдээлэл байршуулаагүй

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/ заасныг зөрчсөн байна.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1				1		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5			1		

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 862,110.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 171,914.5 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,732.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 688,463.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 80.1 хувийг залруулагдаагүй, 19.9 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллгын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Засаг даргын Тамгын газар	3	15,527.7			3	15,527.7	3	15,527.7				
Хоршоо хөгжүүлэх сан	1	1,178.4	1	1,178.4			1	1,178.4				
Орон нутгийн хөгжлийн сан	1	155,208.4	1	155,208.4			1	155,208.4				
Дүн	5	171,914.5	2	156,386.8	3	15,527.7	5	171,914.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллгын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	7	46,129.3	1	1732.0	6	44,397.3						
ИТХ	1	103.1			1	103.1						
ОНХС	1	10,000.0			1	10,000.0						
БХС	1	28,800.0							1	28,800.0		
Нийт дүн	10	85,032.4	1	1,732.0	8	54,500.4	0	0.0	1	28,800.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ЗДТГ	1	0.0					1	0.0				
ИТХ	1	0.0							1	0.0		
ОНХС	1	0.0			1	0.0						
ОННТ	1	0.0			1	0.0						
Дүн	4	0.0	-	-	2	0.0	1	0.0	1	0.0		
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЗДТГ	1	0.0							1	0.0		
ОНХС	2	605,163.4			2	605,163.4						
Дүн	3	605,163.4	-	-	2	605,163.4	-	-	1	0.0		
Нийт дүн	7	605,163.4	-	-	4	605,163.4	1	0.0	2	0.0		

